



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/347

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/122 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нартай 2024 онд байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/122 дугаар тушаалын дагуу Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гэрээг хагас, бүтэн жилээр үнэлж, үнэлгээний дүн, гэрээний талуудад өгөх зөвлөмжийг тухай бүр аймгийн Засаг даргад танилцуулж байхыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн), гэрээний хэрэгжилтийг хангуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (М.Үүрийнбаяр), гэрээнд тусгагдсан үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн сайдын тушаал шинэчлэгдсэнтэй холбоотойгоор 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/681 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М. Хуягбаатар)-т даалгасугай.

ДАРГА

П. ЛХАГВАЖАВ



Захирамж2024
6712011060

Аймгийн Засаг даргын 2024 оны
07 дугаар сарын 02-ны өдрийн А/З.44
дугаар захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Үнэлгээний комиссын дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга

Гишүүд:

Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн удирдлагын хэлтсийн дарга

Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга

Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Мэдээ мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

Монголын Өрхийн Анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбооны Хөвсгөл аймаг дах салбар зөвлөлийн дарга

Харьяаллын иргэний төлөөлөл